



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТУГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар A/15


Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын захирлын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн A/10 дугаар тушаалаар байгуулагдсан 2023 онд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон Алтангэрэлийн Ариунсайхан цаашид үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах боломжгүй тухай өргөдлийг ирүүлсэн тул түүнийг чөлөөлж, тус байгууллагын эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Борын Болортуюаг нөхөн томилсугай.

2.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, зааврын дагуу үнэлгээний хорооны хамт сонгон шалгаруулж, дүгнэлт гарган ажиллахыг Борын Болортуюад даалгасугай.



3130600036